



# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.24. №61 (61)

## ҮЙЛ ЯВДАЛ

### ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН 416,1 КМ ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД БҮТЦИЙГ УГСАРЧ ДУУСГАВ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс таван толгойн хөрөнгө оруулалтаар Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн 416.1 км Төмөр замын дээд бүтцийг угсарч дууссантай холбогдуулан Дорноговь аймагт айлчиллаа.

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого гаргаж төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхдээ хэд хэдэн үетэйгээр ажлаа төлөвлөсөн. Эхний үе нь Таван толгой –Зүүнбаянгийн төмөр замын бүтээн байгуулалт билээ. Хоёр дахь үе Баруун-Урт-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1165 км төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийхээр төлөвлөгдсөн байна.

2020 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Зүүнбаян-Таван толгой чиглэлийн эхний 50 километр төмөр

замыг дуусгаж, хүлээн авч байсан бол өнгөрсөн амралтын өдөр Тавантолгой-Зүүн баян чиглэлийн 416.1 км төмөр замын дээд бүтцийг угсарч дуусгалаа. Тус ажилд Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид гар бие оролцсон ба бүтээн байгуулалтын хүндийг нугалсан гэж хэлж болох юм.

Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор Уул уурхай, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, дотоодын төмөр замын сүлжээгээр дамжуулан Орос, Хятадын төмөр замын сүлжээнд холбогдох, цаашилбал далайн боомтуудад хүрэх, Тавантолгойн ордын нүүрсийг Хятад, Солонгос, Япон улсын зах зээлд хүргэх зэрэг эдийн засгийн бодит үр өгөөжийг өгөх юм.



## ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА

Багшийн хөгжлийн төвийн санаачлагчаар эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх арга зүйн чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт “Шинжлэх ухаан технологийн төсөл боловсруулах арга зүй” сэдвээр БХЭШХ-ийн захирал доктор (PhD), профессор, хурандаа Б.Мөнхсайхан зочин илтгэгчээр оролцож, багш нарт шинжлэх ухаан технологийн төсөл, түүнийг боловсруулах арга зүй, төслийг хэрэгжүүлэх үе шат, ШУТ-ийн Сангаас хэрэгжсэн төслийн өнөөгийн байдал, БХЯ, ЗХЖШ-ын захиалгаар 2020 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын талаар мэдээлэл арга зүйн зөвлөмж өглөө. Энэ нь нийт оролцогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн үр дүн, ач холбогдол өндөр хэлэлцүүлэг болсноороо онцлогтой байв.

Хэлэлцүүлэгт ҮБХИС-ийн багш нарын төлөөлөл болох 86 багш оролцож шинжлэх ухаан технологийн төсөл боловсруулах үйл явц, төсөлд оролцох боломжийн талаар мэдээлэл авахын зэрэгцээ судалгааны арга зүйдээ шинэ мэдлэг мэдээллийг нэвтрүүлсэн чухал хэлэлцүүлэг болсон.

**ҮБХИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ**

## “ХААНЫ ЭРЭЛД-2021” СУРГУУЛИЙГ ДОЛООДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛНА



“Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуулийг Монгол Улсын ЗХЖШ, АНУ-ын Энэтхэг-Номхон цэргийн командлал, Аляска мужийн Армийн үндэсний гвардтай хамтран 18 дахь жилдээ зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. 2020 онд цар тахлын нөхцөл байдлаас

үүдэн тасалдсан бөгөөд энэ жилийн хувьд долоодугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм. Ингэхдээ Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу коронавирусын эсрэг дархлаажуулалтад бүрэн хамрагдсан оролцогчдыг сургуульд оролцуулах, түүнчлэн халдвар хамгааллын тусгай

шаардлагуудыг сургуульд оролцох орнуудад албан ёсоор мэдэгдээд байна.

“Хааны эрэлд-2021” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуульд оролцохыг урьсан ЗХЖШ-ын даргын урилгыг Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй хамтын ажиллагаатай орнуудад илгээснээр өнөөдрийн байдлаар 11 улс, 1 олон улсын байгууллагын 250 гаруй цэргийн алба хаагч оролцох тухайгаа хариу ирүүлж, өөрийн улсдаа бэлтгэл ажлаа хангаж эхэлжээ. Энэ жилийн сургуулийн гол онцлог нь түргэн байрлах хүчний рот болон хоёрдугаар шатлалын хээрийн эмнэлгийг дэлгэж, гүйцэтгэх үүрэгтэй холбоотой сургалтуудыг нэмж явуулах юм байна.

Ирэх зургаадугаар сарын 05-11-ний өдрүүдэд Монгол Улсын Зэвсэгт хүчин болон АНУ-ын талын сургуулийн төлөвлөлтийн баг “Хааны эрэлд-2021” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуулийн төгсгөлийн шатны төлөвлөлтийн хурлаар зохион байгуулалтын бусад асуудлыг тодотгож, тохиролцох юм.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	0

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	22

### АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
27	11

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.443.00	3.502.00
CNY	441.00	444.40
RUB	38.10	39.80
JPY	25.86	26.36
KRW	2.44	2.58

## ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 13  
2021.05.24.  
/ДАВАА ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН  
МОГОЙ САРЫН НАЙМАН  
ЦАГААН ХАР БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:

Жаргал ирнэ.

Наран ургах, шингэх:

05.04-20.34

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал:

Гал.

Аргын тооллын 5 сарын 24, Сумъяа гараг. Билгийн тооллын 13, Салхины эх одтой, хар бич өдөр. Өдрийн наран 5 цаг 04 минутад мандан, 20 цаг 34 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавуулах, угаал үйлдэх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хуваас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэтгэй газар очиход муу, Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одоосод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

52.470

ЭДГЭРСЭН

46.338

НАС БАРСАН

248/13

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2421 (34)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

219

ЭДГЭРСЭН

2166

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 165,772,430

Эдгэрсэн

Нийт: 141,283,741

Нас барсан

Нийт: 3,437,430

## ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	25,741 2,495,568
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	8,133 2,858,085
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	1,234 409,180
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	639 77,570

2021.05.20  
11:00 ЦАГИЙН БАЙДАЛ



## ҮЙЛ ЯВДАЛ

# “ТЭРГҮҮНИЙ АРДЫН АВЬЯАСТАН ХАМТ ОЛОН” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫГ ДҮГНЭЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдаж байгаа томоохон арга хэмжээний нэг нь Зэвсэгт хүчний “Тэргүүний ардын авьяастан хамт олон” шалгаруулах уралдаан юм. Хоёр жил тутамд явагддаг уралдааныг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цахимаар хүлээн авч, энэ өдрүүдэд мэргэжлийн шүүгч нар дүгнэн хэлэлцэж байна. Энэ талаар уралдаан зохион байгуулж явуулах ажлын хэсгийн дарга, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Т.Мөнхсаруулаас тодруулла.

## Уралдааны явцын талаар мэдээлэл өгөхгүй юу?

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсан 100 жилийн ойг тохиолдуулан 2020 оноос эхлэн тус уралдааныг зохион байгуулж явуулах бэлтгэл ажлыг хангасан. Харамсалтай нь цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан авьяаслаг алба хаагчдыг нэг дор цуглуулах боломжгүй болсон учир бүрэн хэмжээний урлагийн тоглолтоо дүрс бичлэгээр бэлтгэн ирүүлэхээр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад албан бичиг хүргүүлсэн. Энэ дагуу Зэвсэгт хүчний 15 нэгтгэл, ангиудаас удирдамжид заагдсан дуу, хөгжим, бүжиг, ардын язгуур урлаг, уран уншлага, шилдэг үзүүлбэр

гэсэн зургаан төрлөөр дүрс бичлэгээр бэлтгэн ирүүлснийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн энэ сарын 21-23-ны өдрүүдэд шүүн дүгнэж байна.

Зэвсэгт хүчний “Тэргүүний ардын авьяастан хамт олон” шалгаруулах урлагийн үзлэг нь Зэвсэгт хүчинд урлаг, соёлыг хөгжүүлэх, тэргүүний ардын авьяастнуудын эгнээг өргөжүүлэх, уран бүтээлчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, хамт олны гар нийлэмжтэй ажиллагааг бэхжүүлэх, орон нутгийн соёл урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, бие бүрэлдэхүүний амралт, чөлөөт цагийг зөв зохиистой өнгөрөөх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Урлагийн үзлэгээр авьяаслаг алба хаагчид мэргэжлийн уран бүтээлчдээс ч дутахааргүй өрсөлддөг ...

-Тийм ээ. “Батлан хамгаалах байгууллагад хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дэд төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний соёлын түвшинг дээшлүүлэх, урлаг, уран сайхны мэдрэмж, авьяасчадварыг хөгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд соёл урлагийн арга хэмжээг ЗХЖШ-аас ЦДБЭЧ-тай хамтран хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Зэвсэгт хүчний “Тэргүүний ардын авьяастан хамт олон” шалгаруулах урлагийн үзлэгээс гадна “Цагаан сар-



Монгол түмний уламжлалт их баяр” тэмцээн, “Байлдагчийн зүрхнээс дуулж байна” урлагийн тоглолт, “Зэвсэгт хүчний тэргүүний ардын авьяастнуудын гала тоглолт” зэргийг дурдаж болох юм.

Дайчдын урлагийн үзлэг нь хэзээнээс эхлэлтэй билээ?

-1922 онд МАХЦ-ийн “Цэрэг ардыг сурган боловсруулах хэлтэс”-ээс цэргийн хороо, ангиудад клуб, суман, батальонд улаан булан байгуулж, хуур, хөгжим зэрэг соёл гэгээрлийн эд хэрэгслээр ханган, дуу, хөгжим, ший жүжгийн дугуйлан, бүлгэм зохион байгуулж эхэлсэн түүхтэй. Энэ үеэр урлагийн авьяастай цэргийн алба хаагчдыг цуглуулан дуу,

хөгжмийн хэсэгчилсэн тоглолт, “Амьд сонин” гэдэг шог гараа, ший жүжиг тавьж, ард иргэдэд үзүүлж байв.

1931 оны дундуур Цэргийн төв клубийн анхны барилгыг барьж, 1932 оны 12 дугаар сарын 12-ны өдөр цэргийн доторх намын байгууллагуудын анхдугаар хуралд зориулан анхны тоглолтоо хийсэн нь Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын байгуулагдсан өдөр, цэргийн анхны тэргүүний ардын авьяастнуудын урлагийн тоглолт хэмээн тооцож, тэмдэглэж ирсэн билээ.

1960-1980 он хүртэл Офицеруудын ордон, ЦДБЭЧ-ын материаллаг бааз, мэргэжлийн

бүрэлдэхүүнийг түшиглэн Ардын армийн урлагийн үзлэгийг жил бүр, 1980 оноос одоог хүртэл 2 жилд 1 удаа зохион байгуулж ирсэн юм.

Энэ удаагийн урлагийн үзлэгийн дүн хэзээ гарах вэ?

-Мэргэжлийн шүүгч нар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги бүрээр нь үзэж, хэлэлцэн дүгнээд 5 дугаар сарын 24-ний өдөр нэгдсэн дүнгээ гаргана. Энэ ташрамд, цар тахлын хүндрэлтэй нөхцөл байдалтай байгаа хэдий ч гэсэн уламжлал болсон урлагийн үзлэгтэй анги, хамт олноо бэлтгэн оролцуулсан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудынхаа удирдлагад талархсанаа илэрхийлье.

Ахлах дэслэгч Д.БОЛОР

## ОФИЦЕР, АХЛАГЧИЙН ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг өнөөдөр Зэвсэгт хүчний 015, 032, 284 дүгээр анги болон Зэвсэгт хүчний нэгдсэн төв лабораториас эхэллээ. Түвшин тогтоох үзлэг нь ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэжлийн түвшин, сахилга, ёс зүйн төлөвшил, бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийн байдал, сэтгэл зүйн байдал зэрэг таван чиглэлийн хүрээнд явагдах бөгөөд дээрх анги, байгууллагуудын хувьд биеийн тамирын бэлтгэлжилтээр өнөөдөр эхэлсэн юм.

Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу түвшин тогтоох үзлэгт Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага,

Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, ЗХЖШ-ын офицер, ахлагч нарыг хуваарийн дагуу бүрэн хамруулна. Үзлэг 2020 оны II, III улиралд багтан явагдана.

Үзлэг нь офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой юм.

## ХӨДӨӨ, ОРОН НУТАГ РУУ ЗОРЧИХ ИРГЭД ДАРААХ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА



Өнгөрсөн бямба гарагаас эхлэн иргэдийн хөдөө, орон нутаг гарах хөдөлгөөнийг нээж байгаа. Монгол Улсын Шадар сайдын 46 дугаар тушаалын дагуу иргэд дараах шаардлагыг хангасан байна.

Дархлаажуулалтын бүрэн тун /2 тун/ авсны дараа 14 хоног өнгөрсөн нотлох баримт шаардлагатай. Энэ тохиолдолд PCR-ын шинжилгээ шаардахгүй.

Сүүлийн дөрвөн сарын хугацаанд коронавирусын халдвараар өвдөж, эдгэрсэн бол эмчийн магадалгаа шаардлагатай.

Эмчийн магадалгааг эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн бол эмнэлгээсээ, гэрээр эмчлүүлсэн бол Өрхийн эрүүл мэндийн төвөөсөө авна.

0-17 насны хүүхдээс шинжилгээ шаардахгүй боловч шинж тэмдэг илэрсэн тохиолдолд түргэвчилсэн шинжилгээ хийнэ.

Бусад тохиолдолд PCR-ын шинжилгээ /72 цаг хүчинтэй/ эсхүл түргэвчилсэн шинжилгээ /48 цаг хүчинтэй/ шаардана.

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС